



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/137

Чингис хот

Хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1 дахь заалт, Улсын Онцгой Комиссын 9 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй сүм, хийдийн үйл ажиллагааг батлагдсан удирдамжийн дагуу хяналт, шалгалтын үйл ажиллагаа явуулах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Бат-Октябрь	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Пүрэвсүрэн	Аймгийн Цагдаагийн газрын Эрүүгийн мөрдөгч, Цагдаагийн ахлах дэслэгч
Гишүүд:	Э.Батхүрэл	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэдээллийн технологийн мэргэжилтэн
	Д.Отгонцолмон	Аймгийн Мэргэжлийн Хяналтын газрын Боловсрол Соёлын Улсын ахлах байцаагч
	Б.Бат-Эрдэнэ	Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах Улсын ахлах байцаагч
	О.Ганбаатар	Улсын Бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагч
	Д.Дэлэг	Гадаадын иргэн харьяатын газрын Зүүн бүсийн Хэнтий аймаг дахь Ахлах мэргэжилтэн
	М.Мөнхнаран	Аймгийн Татварын хэлтсийн Татварын орлогын тасгийн дарга
	Л.Эрийнтовч	Тагнуулын Ерөнхий газрын Хэнтий аймаг дахь хэлтсийн ажилтан

211010375

2.

2. Ажлын хэсгийн гишүүдээс хийгдсэн хяналт шалгалтын ажлын илтгэх хуудсыг авах нэгтгэхийг нарийн бичгийн дарга /Г.Пүрэвсүрэн/-д, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт шалгалтын нэгдсэн тайланг Аймгийн засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Л.Бат-Октябрь/-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА